



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Сүхбаатар аймаг дахь төрийн
аудитын газар

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХУДАЛДАН АВСАН МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН
ҮНЭ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЭС ӨНДӨР БАЙНА.

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СБА-2024/18-16-ШТА-ГА

Баруун-Урт 2024 он



Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn
Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Оюунболд

Утас: 70512127 Цахим хаяг: oyunboldg@audit.gov.mn
Аудитор Э.Алтансүх

Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Аудитор Б.Ганцэцэг

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
БҮЛЭГ А. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТӨСӨВТ ӨРТГИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ БОДИТ ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН ОЛГООГҮЙ БАЙНА.	5
<i>А.1. Тоног төхөөрөмжийн төсөвт өртгийг тодорхойлохдоо мэргэжлийн байгууллагын зах зээлийн үнийн судалгаа, дүгнэлтэд үндэслэх шаардлагатай байна.</i>	<i>5</i>
<i>А.2. Уралдаант шалгаруулалтгүйгээр концессын 2 гэрээ байгуулсан байна.</i>	<i>5</i>
<i>А.3. Зарим төсөл арга хэмжээний урьдчилгаа санхүүжилтийг банкны баталгаагүйгээр болон бодит гүйцэтгэлд үндэслэж санхүүжилтийг олгоогүй байна.</i>	<i>6</i>
БҮЛЭГ Б. КОНЦЕССЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ КОМПАНИУД ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛААГҮЙ, ЗАХИАЛАГЧИЙН ТЕХНИК ХЯНАЛТГҮЙГЭЭР ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА.....	7
<i>Б.1. Барилгын ажил гүйцэтгэх төсөл арга хэмжээг зураг төсөвгүй болон зураг төслийн дагуу гүйцэтгээгүй байна.....</i>	<i>7</i>
<i>Б.2. Зураг төсөвгүй болон зураг төсөв нь магадлалаар баталгаажаагүй зарим төсөл арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлсний улмаас барилгын техник хяналт хэрэгжээгүй байна.....</i>	<i>8</i>
<i>Б.3. Зарим төсөл, арга хэмжээг эс тооцвол нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.....</i>	<i>9</i>
БҮЛЭГ В. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНҮҮД ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА.....	9
<i>В.1. Зарим төсөл, арга хэмжээг эс тооцвол хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.</i>	<i>9</i>
<i>В.2. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.....</i>	<i>10</i>
Холбогдох байгууллагын санал:	11
Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:	15
ДҮГНЭЛТ: 15	
ЗӨВЛӨМЖ:.....	16

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
АИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УИХ	Улсын Их хурал
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл		
Аудит үндэслэл, эрх	хийх бүрэн	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолыг үндэслэн гүйцэтгэв.
Аудитын зорилт		Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг АИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ.
Аудитын хүрээ	хамарсан	Аудитад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг 2023 онд хэрэгжүүлсэн Сүхбаатар аймгийн Засаг дарга, харьяа байгууллагууд, аймгийн Засаг даргын тамгын газар, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Сүхбаатар хот байгуулалт, орон сууц, барилга захиалагчийн алба болон холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайлан, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт		Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа авах арга зүйг ашиглаж аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа		Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Оюунболд, аудитор Э.Алтансүх, Б.Ганцэцэг нар 2024 оны 01 сарын 22-ны өдрөөс 6 сарын 07-ний өдрийг хүртэлх хугацаанд аудитыг гүйцэтгэв.

БҮЛЭГ А. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТӨСӨВТ ӨРТГИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ЭКО ХОРООЛЛЫН АВТО ЗАМЫН АЖЛЫН САНХҮҮЖИЛТИЙГ БОДИТ ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН ОЛГООГҮЙ БАЙНА.

А.1. Тоног төхөөрөмжийн төсөвт өртгийг тодорхойлохдоо мэргэжлийн байгууллагын зах зээлийн үнийн судалгаа, дүгнэлтэд үндэслэх шаардлагатай байна.

1.1.1. Тоног төхөөрөмж худалдан авах төсөл арга хэмжээний өртгийг зах зээлийн үнээс өндрөөр төсөвт тусган, баталж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- “Сумдын Засаг даргын тамгын газарт автомашин худалдан авах-10 сум” төсөл арга хэмжээний төсөвт өртгийг 2,250.0 сая төгрөгөөр баталж, зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авалт хийсэн байх магадлалтай байна.
- “Зөөврийн наадмын талбай - Дарьганга сум” төсөл арга хэмжээний төсөвт өртгийг 400.0 сая төгрөгөөр төсөвт тусган баталсан байна. Бусад аймгуудад хэрэгжсэн ижил төрлийн, ойролцоо төсөл арга хэмжээнүүдийн төсөвт өртгийг судалж үзэхэд 60.0-150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй байна.

1.1.2. Дээрх авто машин болон зөөврийн наадмын талбайн худалдан авалттай холбоотой асуудлыг нарийвчлан шалгах ажиллагаа үргэлжлүүлэн хийгдэнэ.

1.1.3. “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.3.3-т /**холбогдох баримт бичиг, нотлох баримтаар баталгаажсан**, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх;/ гэж заасны дагуу тоног төхөөрөмж худалдан авах төсөл арга хэмжээг мэргэжлийн байгууллагаар зах зээлийн үнийн судалгааг хийлгэсний үндсэн дээр төлөвлөж, төсөвт тусгуулах шаардлагатай байна.

1.1.4. Зураг төсөлгүй болон зураг төсөв нь батлагдаагүй төсөл арга хэмжээнүүдийг төлөвлөж, хэрэгжүүлж нь Барилгын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- **Сүхбаатар сумын Боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан:** сургуулийн дээврийн засварын 159.5 сая төгрөг, худаг гаргах 20.0 сая төгрөгийн ажлыг магадлалаар баталгаажаагүй зураг төслөөр гүйцэтгэсэн.
- **Мөнххаан сум /Эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалт/:** “Цэцэрлэгийн гадна тохижилт”-ын 30.0 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй ажлыг 28.8 сая төгрөгөөр зураг төсөвгүйгээр хийж гүйцэтгүүлсэн.
- **Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардал:** Мал эмнэлгийн аюултай хог хаягдал, химийн бодисыг тээвэрлэх, устгах ажлын төсөв магадлалын ерөнхий дүгнэлтгүй.

А.2. Концессын 2 гэрээг уралдаан шалгаруулалтгүйгээр байгуулсан байна.

1.2.1. “Сумдын Засаг даргын тамгын газарт автомашин худалдан авах-10 сум” автомашин худалдан авах төсөл, арга хэмжээний хувьд урьдчилгаа санхүүжилт олгох эсэх талаар тендерийн баримт бичигт тодорхой зааж өгөөгүй байна.

1.2.2. Тендер зарлахгүйгээр шууд гэрээ байгуулж, төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн дараах зөрчлүүд байна. Тодруулбал “Баруун-Урт сумын 2-р сургуулийн барилгын гадна засварын ажлын зураг төсөл” төсөл арга хэмжээг 33.0 сая төгрөгөөр “Агниста инженеринг ХХК”-иар, “Мал эмнэлгийн аюултай хог хаягдал зайлуулах үйлчилгээ”-г 123.0 сая төгрөгөөр “Элемент” ХХК-иар тус тус гүйцэтгүүлсэн байна. Худалдан авах ажиллагааг тендер сонгон шалгаруулалтгүйгээр зохион байгуулж, шууд гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1 дэх /Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараах нөхцөлд хэрэглэж болно/ заалтыг зөрчсөн. Энэ нь худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимтай нийцэхгүй байна.

1.2.3. Засгийн газрын 2016 оны “Концессын төслүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 37 дугаар тогтоолоор “Орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэйгөөр аливаа төсөл, арга хэмжээг концессын зүйлийг хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон байна. Өөрөөр хэлбэл “Барих-шилжүүлэх” төрлийн концессыг хэрэгжүүлэхийг зогсоосон байна.

1.2.4. Уулбаян, Түвшинширээ суманд төвлөрсөн дулаан, цэвэр ус хангамж, ариутгах татуургын системийг “Барих-Ашиглах-Шилжүүлэх” концессын нөхцөлөөр хэрэгжүүлэх гэрээг “Эм Эс Ки Энд Ти У” ХХК, “Сэтгэшгүй нэмэх” ХХК-тай байгуулсан байна. Тус гэрээний 3.2.3 дахь заалтад бохирын шугам сүлжээний зураг төсөл, угсралт, цэвэрлэх байгууламж барьж, гүйцэтгэх ажлын санхүүжилтийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэхээр тусгасан байна. Өөрөөр хэлбэл энэхүү гэрээ нь “Барих-шилжүүлэх” төрлийн концессын шинжийг агуулж байгаа бөгөөд Засгийн газрын 2016 оны 37 дугаар тогтоолыг зөрчсөн байна. Мөн дээрх 2 концессын гэрээг байгуулахдаа Концессын тухай хуулийн 11-19 дүгээр зүйлийг зөрчиж, уралдаант шалгаруулалтгүйгээр 2023 оны 7 сарын 31-ний өдөр гэрээ байгуулсан байна. Иймд эдгээр нь ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй байгаа тул уг асуудлыг нарийвчлан шалгах ажиллагаа үргэлжлүүлэн хийгдэнэ.

А.3. Сумдын Засаг даргын тамгын газарт автомашин худалдан авах төсөл арга хэмжээний санхүүжилтийг банкны баталгаагүйгээр урьдчилж олгосон, эко хорооллын авто замын ажлыг бодит гүйцэтгэлээс илүү дүнгээр санхүүжүүлсэн байна.

1.3.1. “Сумдын Засаг даргын тамгын газарт автомашин худалдан авах-10 сум” төсөл арга хэмжээний 1,075.0 сая төгрөгийн санхүүжилтийг банкны баталгаагүйгээр “Майнс аг” ХХК-д урьдчилж олгосон. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 44 зүйлийн 2 дахь /Захиалагч урьдчилгаа төлбөрийн дүнтэй тэнцүү хэмжээтэй гүйцэтгэгчийн ирүүлсэн энэ хуулийн 20.2-т заасан баталгааг үндэслэн урьдчилгаа төлбөр төлнө./, 4 /Тендерийн баримт бичигт заагаагүй тохиолдолд захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй./ дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 144 дүгээр тушаалаар баталсан “Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”-ийн гэрээний ерөнхий нөхцөлийн 3-р зүйлийн 12-т захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй гэж заасантай нийцэхгүй байна. Энэ зөрчил нь дараах сөрөг үр дагавартай байна. Тодруулбал бэлтгэн нийлүүлэгч авто машиныг нийлүүлэх чадамжгүй болох үед урьдчилж олгосон санхүүжилтийг буцаан авахад хүндрэл үүсэх, олж авах боломжгүй болох эрсдэлтэй юм.

1.3.2. Эко хорооллын авто замын ажлын гүйцэтгэгч Монгол зам групп ХХК-д санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс 267.0 сая төгрөгөөр илүү олгосон байна. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй нь “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.12 дахь заалтыг зөрчсөн байна. Илүү олгосон санхүүжилтийн хүрээнд гүйцэтгэгч компани ажлаа гүйцэтгээгүй байна. Иймд захиалагчийн зүгээс тус компанийн гүйцэтгэж байгаа дараах ажлуудын санхүүжилтийг олгоогүй байна. Үүнд:

- “Баруун-Урт сумын төвийн хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн хэсэгчилсэн засвар, нөхөөс”
- “Ногоон хотхоны доторх тохижилт болон авто зогсоол барих/ Баруун-Урт сум 1-р баг/”

1.3.3. Цэцэрлэгийн барилгын их засвар /Баруун-Урт сум, 3-р цэцэрлэг/ төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн төсөв нь бодит гүйцэтгэлээс зөрүүтэй байгаа тул өөрчлөлтийн төсвийг бодит гүйцэтгэлд үндэслэн гаргуулж, дахин хяналт тавьж баталгаажуулах шаардлагатай байна.

БҮЛЭГ Б. КОНЦЕССЫН ГЭРЭЭГЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА 2 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ЗАХИАЛАГЧИЙН ТЕХНИК ХЯНАЛТГҮЙГЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЖ БАЙНА.

Б.1. Барилга угсралтын ажлыг гүйцэтгэх төсөл арга хэмжээг зураг төсөвгүй гүйцэтгэх, мөн зураг төслийн дагуу хэрэгжүүлээгүй байна.

2.1.1. Уулбаян, Түвшинширээ суманд төвлөрсөн дулаан, цэвэр ус хангамж, ариутгах татуургын системийг “Барих-Ашиглах-Шилжүүлэх” концессын гэрээний зураг төсөв нь барилгын ажил эхэлж, далд ажил хийгдэж дууссанаас хойш магадлалын дүгнэлт гаргуулсан байна. Тодруулбал:

- Уулбаян сумын концессын гэрээний “Гадна дулаан хангамжийн шугамын ажлын зураг төсөл, төсөв” нь 2023.12.26-ны өдөр 3,790.0 сая төгрөгөөр магадлалаар баталгаажсан.
- Түвшинширээ сумын концессын гэрээний хувьд “Гадна дулаан хангамжийн шугамын ажлын зураг төсөл, төсөв” нь 2023.12.26-ны өдөр 3,258.4 сая төгрөгөөр магадлалаар баталгаажсан.

2.1.2. Дээрх концессын гэрээний хэрэгжилтийн явцтай ГХБХБГ-аас 2023 оны 9 сарын 27-28 ны өдрүүдэд танилцаж “Сэтгэшгүй нэмэх” ХХК-д 2023.10.03-ны өдрийн 01/376 тоот, 2023.11.28-ны өдрийн 01/489 тоот албан бичгээр тус тус хугацаатай албан шаардлага, “Эм Эс Ки Энд Ти У” ХХК-д 2023.10.03-ны өдрийн 01/375 тоот, 2023.10.03-ны 01/375 тоот албан бичгээр хугацаатай албан шаардлага хүргүүлсэн байна. Эдгээр концессыг хэрэгжүүлэгч компаниуд захиалагчийн хяналтын гэрээ байгуулаагүй, техник хяналтгүйгээр төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байна.

2.1.3. Барилгын угсралтын ажлын төсөл арга хэмжээг магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй гүйцэтгэсэн дараах 3 зөрчил илэрсэн бөгөөд энэ нь Барилгын тухай хуулийн 40.2 дахь заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Мөнххаан сумын цэцэрлэгийн гаднах тохижилтын ажлыг зураг төсөвгүйгээр “Оточ-Оргил” ХХК-иар 28.8 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн. /Зураг төсөлгүй/

- Мал эмнэлгийн газрын аюултай хог хаягдлыг зөөх, тээвэрлэх, аюулгүй болгох устгах 123.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Элемент” ХХК гүйцэтгэсэн боловч биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийгээгүй. /Магадлалгүй/
- Уурын зуухны тогоо шинэчлэх /Баяндэлгэр сумын эрүүл мэндийн төв/ төсөл арга хэмжээг “Мөнх нарны элч” ХХК 15.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн боловч төсөв нь магадлалаар баталгаажаагүй.

2.1.4. Барилгын угсралтын ажлыг зураг төслийн дагуу гүйцэтгээгүй дараах 2 зөрчил илэрсэн бөгөөд энэ нь Барилгын тухай хуулийн 40.1.1 дэх заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Уурын зуухны тогоо шинэчлэх /Баяндэлгэр сумын эрүүл мэндийн төв/ төсөл арга хэмжээ /15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/-ний ажлын чанар хангалтгүйн улмаас зуухны амны хэсэг 2 удаа цуурч, ус алдсан, дотор хана дотогш цүлхийж цаашид ашиглах боломжгүй болсон.
- “Тусгай зориулалтын автомашинуудын авто гарааш барих-Онцгой байдлын газар” төсөл арга хэмжээний авто гараашны сэндвичийн хананы төмөр зэвэрч цоорсон, усны хаялга хөндийрч зааг гарсан, ховхорч бутарсан, ус урсах ховил, урсах болон зайлуулах тосгуур, хамгаалалтын төмөр угсрагдаагүй.

2.1.5. Алтан овоог тайх ёслолын хүрээнд Дарьганга суманд 398.4 сая төгрөгөөр наадмын зөөврийн талбай худалдан авсан. Уг наадмын талбай нь зөөврийн гэх боловч төв талбай нь газарт 1м гүнд суурилуулсан, зөвхөн дээврийн даавууг зөөх боломжтой, зүүн талын урлагийн театрын цагаан дээвэр салхинд хийсэж, нурсан байна. Чанартай холбоотой асуудлыг барьцаа хөрөнгөөр шийдвэрлэх шаардлагатай юм.

Б.2. Зураг төсөвгүй болон зураг төсөв нь магадлалаар баталгаажаагүй 3 төсөл арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлсний улмаас барилгын техник хяналт хэрэгжээгүй байна.

2.2.1. “Мөнххаан сумын цэцэрлэгийн гаднах тохижилт”, “Мал эмнэлгийн газрын аюултай хог хаягдлыг зөөх, тээвэрлэх, аюулгүй болгох устгах ажил”, “Уурын зуухны тогоо шинэчлэх /Баяндэлгэр сумын эрүүл мэндийн төв/” төсөл арга хэмжээнүүд магадлалаар баталгаажсан зураг төсөлгүйн улмаас захиалагчийн техник хяналт хэрэгжээгүй байна. Төсөл арга хэмжээг барилгын техник хяналтгүй хэрэгжүүлснээр чанаргүй болох, магадлалаар баталгаажаагүй төсвөөр гүйцэтгүүлсэн нь төсвийн хөрөнгийг хэмнэлтгүй зарцуулах зэрэг сөрөг үр дагавартай байна. Иймд АЗДТГ-ын Хөрөнгө оруулалтын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс зураг төсөлгүй болон зураг төсөв нь магадлалаар баталгаажаагүй төсөл арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөхгүй байх шаардлагатай байна.

2.2.2. “Тусгай зориулалтын автомашинуудын авто гарааш барих /Онцгой байдлын газар/”, “Цэцэрлэгийн барилгын их засвар /Баруун-Урт сум, 3-р цэцэрлэг/” төсөл арга хэмжээний барилгын техник хяналтыг ГХБХГ хэрэгжүүлсэн боловч ажлын чанар хангалтгүй, тоо хэмжээнд өөрчлөлт орсон байхад бодит гүйцэтгэлд үндэслэсэн гүйцэтгэлийн төсвийг гаргуулж, хяналт тавьж ажиллаагүй байна.

2.2.3. Сүхбаатар сумын 100 ортой хүүхдийн дотуур байрын барилгын ажлын гүйцэтгэгчээр “Жавхлан Хүслэн” ХХК 4,217.0 сая төгрөгөөр шалгарсан боловч

барилгын ажлын зөвшөөрөлгүй ажлыг эхлүүлсэн байна. Энэ нь Зөрчлийн тухай хуулийн 12.1.2 дугаар зүйлд заасны дагуу хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох үндэслэл болж байна.

2.2.4. Захиалагч нь барилгын **техник хяналтын** зардлыг барилга угсралтын ажилд техникийн хяналт хэрэгжүүлсэн байгууллагад олгох зохицуулалттай байна. Гэтэл АЗДТГ-ын ХБТХОХ-ийн албан хаагч нар барилгын техник хяналт тавих чиг үүрэг байхгүй байтал төсөл арга хэмжээний гүйцэтгэл, төсөв санхүүгийн хяналт тавихтай холбоотой албан томилолт, тээвэр шатахуун, хоол, урамшууллын зардлыг барилгын техникийн хяналтын зардлаас санхүүжүүлж, төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна. Тодруулбал “Барилгын төсөв зохиох дүрэм”-ийн 6.1-д /Захиалагчийн **техникийн хяналтын** зардлыг нэгдсэн төсвийн тооцооны 2-7 дугаар бүлгийн дүнгээс 2 хувиар тооцно. Нэгдсэн төсөв зохиогдоогүй нөхцөлд барилга угсралтын ажлын төсөвт өртгийн 2 хувиар тооцно./ гэж заасан байна. Өөрөөр хэлбэл барилгын техникийн хяналт хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгууллагаар техникийн хяналтыг хэрэгжүүлэх зардлыг төсөвт өртгийн 2 хувиар тооцсон зардлаар санхүүжүүлэхээр байна. Дээрх зөрчил нь Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 83 дугаар тушаалын 2.1.4 дэх заалтыг зөрчсөн байна. Цаашид ХБТХОХ нь төсөв, санхүүгийн хяналтыг хэрэгжүүлэхдээ АЗДТГ-ын төсвөөс холбогдох зардлыг гаргуулах шаардлагатай байна.

Б.3. Нягтлан бодох бүртгэлд 3 төсөл, арга хэмжээг тусгаагүй байна.

2.3.1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн барилга угсралтын ажил болон тоног төхөөрөмжийг холбогдох байгууллагын данс бүртгэлд тусгасан байна.

2.3.2. Харин өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахад зориулж 85.8 сая төгрөгөөр малын тэжээл, улаан буудай, өвс тэжээл худалдан авч, данс бүртгэлд бүртгээгүй зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.4.2 дахь заалтыг зөрчсөн байна. Энэ нь хөрөнгийн зарцуулалтад нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байгаа бөгөөд хяналтгүй зарцуулах эрсдэлтэй байна.

2.3.2. Сүхбаатар сумын “Боловсрол, эрүүл мэндийн салбарын албан хаагчдын орон сууцны дэд бүтэц, шугамын өргөтгөл”-ийн ажил /648.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ дууссан боловч, шугам сүлжээнд холбогдох орон сууцны барилга баригдаагүйн улмаас тус шугам сүлжээг ашиглалтад хүлээж аваагүй тул данс бүртгэлд тусгаагүй байна.

БҮЛЭГ В. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНҮҮД ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА.

В.1. Баяндэлгэр сумын ЭМТ-ийн уурын зуухны тогоо, Сүхбаатар сумын орон сууцны дэд бүтэц, шугамын өргөтгөлийн ажлыг эс тооцвол хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.

3.1.1. Орон нутгийн нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн дараах ажлууд төслийн хугацаанд хэрэгцээ шаардлагатай, үр дүнгээ өгсөн төсөл арга хэмжээ болжээ. Тодруулбал: Аймгийн Онцгой байдлын газрын авто гарааш, Мал эмнэлгийн байгууллагад нийлүүлэгдсэн 11 төрлийн тоног төхөөрөмж, Стандарт хэмжилзүйн

хэлтсийн 1 болон 3 фазын тоолуур шалгах эталон төхөөрөмж, Сумдын Засаг даргын тамгын газарт автомашин худалдан авах-10 сум, Хилийн цэргийн ангиудад дрон, хяналтын камер, Соёлын төвүүдийн тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар ашиглаж байгаа бөгөөд сургууль, цэцэрлэгийн их засварын ажил үр дүнгээ өгч дусаал гоожихгүй, дулаан алдагдал багассан байна.

3.1.2. Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн уурын зуухны усан халаалтын тогоог Мөнх нарны элч ХХК 15.0 сая төгрөгөөр нийлүүлж 2024 онд данс бүртгэлд тусгасан боловч дахин ашиглах боломжгүй болсон байна. Чанарын баталгаат хугацаа дуусаагүй байхад зуухны тогоо ашиглах боломжгүй болж, эвдэрсэн тул гүйцэтгэгч компаниар засуулах шаардлагатай.

3.1.3. “Боловсрол, эрүүл мэндийн салбарын албан хаагчдын орон сууцны дэд бүтэц, шугамын өргөтгөл”-ийн ажил /648.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ дууссан боловч, шугам сүлжээнд холбогдох орон сууцны барилга баригдаагүйн улмаас тус шугам сүлжээ ашиглагдахгүй байна.

В.2. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

3.2.1. Мал эмнэлгийн байгууллагад нийлүүлэгдсэн 11 төрлийн тоног төхөөрөмжийн хувьд тус байгууллагын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж байна. Хуучин ашиглаж байсан тоног төхөөрөмжүүд нь ОХУ-д үйлдвэрлэгдсэн ашиглалтын хугацаа дууссан, зарим тоног төхөөрөмжүүд ашиглах боломжгүй болсон байна. Мөн шинэ тоног төхөөрөмж ашигласнаар үндсэн үйл ажиллагааны орлого 2023 онтой харьцуулахад 2024 оны эхний 5 сарын байдлаар 2.0 сая төгрөгийн орлого нэмэгджээ. Тухайлбал өмнө нь 1 төрлийн шинжилгээ хийж төлбөр авдаг байсан бол шинэ тоног төхөөрөмжтэй болсноор 5 төрлийн шинжилгээ хийж төлбөр авч байна.

3.2.2. Мөнххаан сумын бага сургууль, нэгдсэн дотуур байр, Түмэнцогт сумын спорт заалны дээврийн засвар, 3-р цэцэрлэг, 2-р сургууль, Баяндэлгэр сумын ЭМТ-ийн гадна фасад дулаалгын ажил хийгдсэнээр өрөөний температур өвлийн улиралд 15-23 градустай ердийн температурт хүрдэг, дээврээс дусаал гоождоггүй болсон үр дүнтэй байна.

3.2.3. Онцгой байдлын газрын гал унтраах тусгай зориулалтын авто машины бэлэн байдлыг хангахад зориулалтын авто машины гарааш шаардлагатай байсныг шийдвэрлэж дулааны гадна шугам сүлжээ, цэвэр усны шугамын хамт гүйцэтгэсэн. Тус гарааш баригдсанаар Онцгой байдлын газрын бэлэн байдлын томилгоот автомашинууд дулаан гараашаар бүрэн хангагдсан байна.

3.2.1. Стандарт хэмжилзүйн хэлтсийн 1 болон 3 фазын тоолуур шалгах эталон төхөөрөмж худалдан авснаар цахилгаан хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын орлого өмнөх оноос 3.1 сая төгрөгөөр өсөж үр дүнгээ өгсөн байна.

---oOo---

Холбогдох байгууллагын санал:



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА

Нутгийн удирдлагын ордон, 7 дугаар баг, Баруун-Урт сум,
Сүхбаатар аймаг, 22075 Утас: (976) 70518585
Цахим шуудан: info@sukhbaatar.gov.mn
Цахим хуудас: www.sukhbaatar.gov.mn

2024.06.17 № 01/760
танай 2024.06.10 -ны № 380 -т

Тайлбар хүргүүлэх тухай

2023 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцаад дараах тайлбарыг хүргүүлж байна. Тайланд тусгагдсан зарим дүгнэлттэй санал нийлэхгүй байгаа тул холбогдох тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

Зарим тоног төхөөрөмжийг зах зээлийн үнээс өндөр худалдан авалт хийсэн:

Сумдын Засаг даргын Тамгын газарт автомашин худалдан авах (10 сум)

Захиалагч байгууллагаас автомашиныг төсөвт тусгахдаа автомашин импортлогч байгууллагуудаас үнийн судалгаа мэдээлэл авсны үндсэн дээр төсөвт тусган баталсан. Дээрх 10 сумын ЗДТГ-ын албан хэрэгцээний автомашины тендер сонгон шалгаруулалт нь tender.gov системээр 2023.04.20-д нээлттэй тендер зарласан ч оролцогч орж ирээгүй, ахин 2023.05.22-д нээлттэй тендер сонгон шалгаруулалт зарласан. Батлагдсан ТББ-т өрсөлдөөнийг хязгаарласан ямар нэгэн заалт байхгүй тул тендерт ямар ч хуулийн этгээд оролцож үнийн санал илгээх боломжтой байсан.

Уг тендерт 1 оролцогч тендер ирүүлж, ирүүлсэн тендер нь шаардлага хангасан тул Майнс Ап ХХК-д гэрээ байгуулах зөвлөмж ирсний үндсэн дээр худалдан авах гэрээ байгуулагдсан. Мөн захиалагч байгууллагаас техникийн тодорхойлолтоо боловсруулахдаа хөдөө орон нутагт туулах чадвартай, хэрэгцээ шаардлагатайг харгалзан стандарт тоноглолоос гадна нэмэлтээр өвлийн дугуй 4 ширхэг, ухрах камер, андройд хөгжим, дотор цонх тень наасан байх шаардлагыг нэмж тусгасан. Нийлүүлэгч Майнс Ап ХХК нь Nissan Patrol Y61 Grx загварын нэмэлт тоноглол бүхий автомашиныг нэг ширхгийг 225,000,000 (хоёр зуун хорин таван сая) төгрөгөөр нийт 10 ширхгийг 2,250,000,000 (хоёр тэрбум хоёр зуун тавин сая) төгрөгөөр нийлүүлсэн билээ.

Дээрх автомашин нь үйлдвэрийн энгийн стандарт тоноглолтой манай үзэсгэлэнгийн танхимд борлуулагдаж буй автомашинаас тоноглолын хувьд өөр бөгөөд санал болгосон үнэд тендерийн шаардлагад тусгасан нэмэлт тоноглолуудын үнээс гадна манай орны эрс тэс уур амьсгал, замын нөхцөл байдалд тохируулан рамны бэхэлгээ, 8 удаагийн урсгал үйлчилгээ болон ажлын хөлс, мөн автомашин тус бүрт 2 жилийн хугацаатай 6 сая төгрөгийн сэлбэг болон сервис үйлчилгээний эрхийг багтаасан үнийн саналыг ирүүлсэн. Майнс Ап ХХК-иас ирүүлсэн албан бичгийг хавсаргав.

Мөн дээрх автомашинуудын тендерийг зарлахад оролцогч орж ирэхгүй, тухайн үед чингэлэг тээвэр гацсан валютын ханш өсөлттэй, БНХАУ-ын Шинганг далайн боомтод

чингэлгийн хүрэлцээгүйн улмаас Монгол улс руу ачигдах 4500 гаруй чингэлгийн бөөгнөрөл үүсэж, зарим тохиолдолд 70-90 хоног хүртэлх хугацаанд ачаа тээвэр, боомт болон хил гаальтай холбоотойгоор тээврийн үнэ ч мөн адил энгийн үеэс ам долларын ханш ч өссөн нөхцөл байдалтай байсан. Иймд бид зах зээлийн үнээр дээрх автомашинуудыг авч нийлүүлсэн бөгөөд 2023-2024 оны өвөлжилт хүндэрсэн Сүхбаатар аймгийн бүх сумдад төмөр зуд нүүрлэсэн цаг үед хэрэгцээ шаардлагатай хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөж хэрэгжүүлсэн болно.

Зарим төсөл арга хэмжээнүүдийг зураг төсөвгүй болон магадлалаар батлагдаагүй байхад хэрэгжүүлсэн байна гэж дүгнэлтэд тусгасан байна. Инженерийн хийцтэй худаг уст цэг гаргах, цэцэрлэгийн гаднах тохижилт, зөөврийн тоглоомын талбай байгуулах, нам даралтын уурын зуухны тогоо шинэчлэх ажлууд нь 10-30 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр жилээс жилд аймаг, сумдын төсөвт батлагдан хэрэгждэг. Бодит байдал дээр дээрх ажлуудад ажлын зураг хийлгээд зураг төсвийг магадлуулах боломж байхгүй, барилгын хөгжлийн төв иймэрхүү зураг болон төслийг магадалж хянаж өгөхгүй, тийм боломж бололцоо ч байхгүйг гэдгийг харгалзан үзнэ үү.

Мөн 1.2.2-т тендер зарлахгүйгээр шууд гэрээ байгуулсан зөрчлүүд байна гэсэн байна. Баруун-Урт суманд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний тендерийг tender.gov.mn системээр 2022.05.11, 2022.05.31, 2022.06.27, 2022.07.19, 2022.09.26-д 5 удаа зарлаж, 5 дахь зарлалтанд шаардлагад нийцсэн тендер ирүүлж "Гамшгаас хамгаалах судалгаа шинжилгээний үндэсний төв"-өөр гэрээний үндсэн дээр хийлгэж хүлээн авсан байна.

Эко хорооллын автозамд бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгож, 2 автозамын ажилд санхүүжилтийг олгоогүй байна гэж туссан байна.

Монгол зам групп ХХК нь 2023 онд Эко хорооллын автозамын ажлын 499,9 сая төгрөг (ОНХС), ногоон хотхоны доторх тохижилт болон авто зогсоол барих 498,3 сая төгрөг (ЗС), Баруун-Урт сумын төвийн хатуу хучилттай автозам, замын байгууламжийн хэсэгчилсэн засвар нөхөөс 299,8 сая төгрөг (ЗС)-ийн гэрээг тус тус байгуулсан. 2023 онд Монгол зам групп ХХК-д Автозамын сангаас 387,1 сая төгрөгийг эко хорооллын автозамын санхүүжилтэд шилжүүлсэн. Эко хорооллын дундах автозамын асфальтан хучилтыг 10 сарын сүүлээр хийхээр тооцож бэлтгэл ажлаа хангасан ч энэ үед их хэмжээний цас орж асфальтан хучилтын ажил хийх боломжгүй нөхцөл байдал үүссэн тул хучилтын ажлыг хяналтын байгууллагаас зогсоосон. Иймд эко хорооллын автозамд өгсөн санхүүжилтийг тус компанийн автозамын засвар нөхөөс болон ногоон хотхоны автозамын ажлын санхүүжилтэд шилжүүлэн тооцож ОНХС болон автозамын сан хооронд залруулга хийж алдаа дутагдлыг 2023 оны төсвийн жилд багтаан залруулсан болно. Дээрх 3 гэрээт ажлын бодит гүйцэтгэл 457,0 сая төгрөг үүнээс 2023 онд гүйцэтгэлээр 387.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

2.2.4-т Захиалагчийн хяналтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан гэж дүгнэсэн байна.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй ажлуудад ТБОНӨХБАҮХАТХ-ийн 48 дугаар зүйлийн дагуу Аймгийн засаг даргаас Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст тухай бүр өөрийн эрх хэмжээний хүрээнд захирамж гарган гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах захиалагчийн чиг үүргийг даалгасан байдаг. Мөн ТБОНӨХБАҮХАТХ-ийн 48.2.7-д Худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах гэж заасан байна. Мөн Засгийн

газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийг баталсан ба энэ дүрмийн 3.11-т Захиалагч барилга байгууламжийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас хийх үзлэг, шалгалтын ажилд оролцож, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах ажлыг зохион байгуулах, 3.18-т Захиалагч барилгын үйл ажиллагаанд холбогдох норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих замаар хувийн, нийтийн болон гуравдагч этгээдийн эрх, ашиг сонирхлыг хамгаална гэж заасан байна. Иймд захиалагч байгууллага нь дээрх хууль тогтоомжид заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд болон захиалагчийн хяналтын байгууллага, техник технологийн хяналтын гэрээлэгч байгууллагын үйл ажиллагааг давхар хянаж баталгаажуулах, явцын хяналтыг тодорхой үе шатуудад хийх, гүйцэтгэлийг баталгаажуулах шаардлага үүсдэг. Энэ чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тухай бүр захиалагчийн хяналтын зардлаас холбогдох гүйцэтгэлд үндэслэн олгосон. Иймд хөрөнгө оруулалтын ажлын үр ашгийг дээшлүүлэх, амжилттай хэрэгжүүлэх, ажил гүйцэтгэх үе шатанд үүссэн аливаа асуудлыг шийдвэрлэж батлагдсан хөрөнгө оруулалтыг төсвийн жилд багтаан хэрэгжүүлж ашиглалтад оруулахад захиалагчийн хяналтын зардал зарцуулагдах ёстой. Иймд хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу Захиалагчийн хяналтын зардлыг тухай бүр захиран зарцуулах эрх үүрэгтэй субъект мөн гэж үзэж байна. Танай байгууллагаас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх үйл явц хангалтгүй, алдаа зөрчлүүд буурахгүй их байгаа талаар тайлангуудад дурдсан тул бид гэрээгээр захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй байгууллагын үйл ажиллагаанд давхар хяналт тавин ажиллах болно.

Химийн хортой бодис устгалыг шууд гэрээгээр гүйцэтгэсэн талаар:

2004 оны 2 дугаар сард гарсан мал, амьтны гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний халдваргүйжүүлэлтэд ашиглах зорилгоор улсын нөөцөөс Мал эмнэлгийн албанд 6,0 тн форфональдегид гэдэг бодис ирж, өвчин оношлогдсон сумдад хуваарилан ариутгал, халдваргүйжүүлэлтэд хэрэглэж байсан. Тухайн үед Наран, Баяндэлгэр сумын голомтод ажиллаж байсан малын эмч, ОБГ-ын ажилтан нар хордлого авч, эрүүл мэндийн үзлэгээр элэг бусад эд эрхтний өөрчлөлттэй Аймгийн нэгдсэн эмнэлэгт хор саармагжуулах эмчилгээ хийлгэсэн.

Үүнээс үүдэн тухайн үед улсын МХЕГ-ын улсын байцаагч орон нутагт ажиллаж байснаар тухайн бодисоос дээж авч холбогдох байгууллагад шинжилгээнд явуулж шинжлүүлэхэд “Хүн, байгаль орчинд 3-5 дахин илүү хортой бодис байна” гэсэн акт гарсан тул сумдаас үлдэгдэл эмийн бодисуудыг татан авч нийт форфанальдегид 4200 литр, 500 кг идэмхий натри зэргийг 2023 оныг хүртэл 19 жил байгууллагын хашаанд хадгалж байв.

Химийн хортой бодисын талаар тухайн үед 2005 онд МЭА-ны даргаар ажиллаж байсан Ж.Одсэр эмч аудитын байгууллагад тайлбар өгч холбогдох байгууллагуудад хандаж байсан, мөн 2009 онд МЭА-ны дарга Т.Дашсүрэн аймгийн Засаг даргад уламжлан ХХААЖДҮ-ийн сайд Т.Бадамжунай, БОАЖ-ын сайд Л.Гансүх нарт хандаж байсан байдаг.

2017 оноос ХХААГ-ын дарга болон миний бие гоц халдварт өвчний үед ирж ажиллаж байсан УОК-ын гишүүд холбогдох удирдлагуудад ХХААХҮ-ийн дэд сайд Ж.Сауле, төрийн нарийн бичгийн дарга Д.Энхбат нарт удаа дараа хүсэлт тавьж химийн хортой бодисыг хэрхэх талаар шийдвэрлэж өгөхийг хүсэж байсан.

Байгаль орчин аялал жуулчлалын яам, Хими химийн технологийн хүрээлэн, ОБЕГ-аас аюултай хог хаягдлыг устгадаг, саармагжуулдаг устгалын төвлөрсөн цэг байгуулагдаагүй, саармагжуулахад их хэмжээний хүчил шаардагдах, битүү байр сав

хэрэгтэй тул орон нутагтаа аюулгүй байдлыг нь хангасан агуулахад түр хадгалж байх зөвлөмж, тайлбар хариуг ирүүлж байсан билээ.

2017 оны 12 дугаар сарын 10-нд аймгийн МХГ-ын улсын байцаагч нар шалгалт хийж химийн бодисын агуулах шаардлага хангахгүй, олон жил хадгалсан бодисын төмөр сав нь идэгдэж нимгэрсэн, улмаар дэлбэрэх магадлалтай, тэсрэлт явагдсан тохиолдолд хялбар шидэгдэх, галд тэсвэргүй материалаар агуулах баригдсан, аюул эрсдэл өндөр байгаа тул шаардлагатай хамгаалах арга хэмжээ авах, асгарсан бодисыг төмөр саванд хийх, нар салхинаас яаралтай хамгаал гэж улсын байцаагчийн 17-06-017/97 тоот дүгнэлтээр “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй, химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах MNS 6458:2014” стандартыг хангахгүй, 17-04-024/155 зөвлөмжөөр “Химийн хорт болон аюултай бодис хадгалах үндсэн шаардлага, журам зөрчсөн, хүний эрүүл мэнд байгаль орчинд шууд болон шууд бусаар хохирол учруулах нөхцөл байдал үүссэн” зэрэг асуудлуудыг тавьж маш яаралтай аюулгүй болгох арга хэмжээ ав гэж үүрэг, чиглэл болгож Прокурорт зөрчлийн хэрэг нээж байсан. Үүнтэй холбогдуулан аймгийн Онцгой Комиссын хуралд асуудлыг хэлэлцүүлэн агуулахын гадна талын битүүмжлэлийг сайжруулахад 3.5 сая төгрөг шийдвэрлүүлэн блокоор битүүмжлэн янзлан засаж байсан.

Мөн аймгийн Засаг даргын 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Хөрөнгө гаргах тухай” А/27 тоот захирамжаар асгарсан химийн бодисуудыг савлуулах, аюулгүй болгох 4505550 төгрөгийг шийдвэрлүүлэн ОБЕГ-ын Үндэсний аврах бригадын химийн ажиллагааны багийн 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг маш хүнд нөхцөлд ажиллаж 10 ширхэг төмөр сав бүхий 60 литртэй идэмхий натрийг гялгар уутаар битүүмжлэн, 4 ширхэг 180 литрийн хуванцар саванд гадна асгарсан идэмхий натрийг, 2 ширхэг 200 литрийн формальдегид битүүмжлэн аюулгүй болгосон ба бусад формальдегидуудад аюултай нөхцөл байдал үүссэн байсан тул хүрэлгүй агуулахыг цоожлон битүүмжилсэн.

2019 оноос хойш аюултай хог хаягдал устгадаг компани эрэн сурвалжлан ажиллаж байсан ба 2022 онд “Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх” түр зөвшөөрөл Элемент ХХК 1 жилээр авсныг тогтоож тухай компанид хүсэлт гарган хуулийн дагуу холбогдож ажилласан. Тус компани нь улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөлтэй ганц компани байсан тул дулааны улирал эхлэхээс өмнө химийн бодисыг аюулгүй болгох шаардлага үүсэж аймгийн ОК-ын хурлаар оруулан хөрөнгө мөнгийг шийдвэрлүүлж устгал хийхтэй холбогдуулан хөрсний дээжүүдийг авхуулж, шаардлагатай арга хэмжээг яаралтай авч ажилласан.

Бидний зүгээс аудитаар илэрсэн алдаа зөрчлийг бууруулах, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар тодорхой ахиц гарган ажиллаж байна.

Хавсралт: “Майнс Ап” ХХК-ийн ирүүлсэн албан мэдэгдлийг хүргүүлээ.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ

Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:

Аймгийн Засаг даргаас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

Ирүүлсэн санал, тайлбар	Төрийн аудитын байгууллагын тайлбар, тайланд оруулсан өөрчлөлт
Тайлбар 1	1.1.1-тэй холбоотой асуудлаар тайлбар ирүүлсэн бөгөөд аудитын тайланд /“Сумдын Засаг даргын тамгын газарт автомашин худалдан авах-10 сум” төсөл арга хэмжээний төсөвт өртгийг 2,250.0 сая төгрөгөөр баталж, зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авалт хийсэн байх магадлалтай байна./ гэж өөрчлөлт оруулсан.
Тайлбар 2	1.1.2-той холбоотой асуудлаар тайлбар ирүүлсэн бөгөөд аудитын тайланд /Дээрх авто машин болон зөөврийн наадмын талбайн худалдан авалттай холбоотой асуудлыг нарийвчлан шалгах ажиллагаа үргэлжлүүлэн хийгдэнэ./ гэж өөрчлөлт оруулсан.
Тайлбар 3	1.1.4-тэй холбоотой асуудлаар тайлбар ирүүлсэн бөгөөд аудитын тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.
Тайлбар 4	1.2.2-той холбоотой асуудлаар тайлбар ирүүлснийг хүлээн авч аудитын тайланд залруулсан.
Тайлбар 5	1.3.2-той холбоотой асуудлаар тайлбар ирүүлсэн бөгөөд аудитын тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.
Тайлбар 6	2.2.4-той холбоотой асуудлаар тайлбар ирүүлсэн бөгөөд аудитын тайланд агуулгын хувьд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн. Аудитын тайланд дараах агуулгыг нэмж тусгасан. /Тодруулбал “Барилгын төсөв зохиох дүрэм”-ийн 6.1-д /Захиалагчийн техникийн хяналтын зардлыг нэгдсэн төсвийн тооцооны 2-7 дугаар бүлгийн дүнгээс 2 хувиар тооцно. Нэгдсэн төсөв зохиогдоогүй нөхцөлд барилга угсралтын ажлын төсөвт өртгийн 2 хувиар тооцно./ гэж заасан байна. Өөрөөр хэлбэл барилгын техникийн хяналт хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгууллагаар техникийн хяналтыг хэрэгжүүлэх зардлыг төсөвт өртгийн 2 хувиар тооцсон зардлаар санхүүжүүлэхээр байна./
Тайлбар 6	1.2.2-той холбоотой асуудлаар тайлбар ирүүлсэн бөгөөд аудитын тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.

Дүгнэлт:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Зах зээлийн үнийн судалгаа хийдэг мэргэжлийн байгууллагын дүгнэлт, тайланд үндэслэн тоног төхөөрөмжийн төсөвт өртгийг тодорхойлж, төсөвт тусгаагүй нь автомашин болон зөөврийн наадмын талбайг зах зээлийн үнээс өндрөөр худалдан авсан зөрчлийн суурь шалтгаан болсон байна.
- Уулбаян, Түвшинширээ сумдын төвлөрсөн дулаан, цэвэр ус хангамж, ариутгах татуургын системийг “Барих-Ашиглах-Шилжүүлэх” нөхцөлөөр

концессын гэрээ байгуулсан боловч “Барих-шилжүүлэх” нөхцөлтэйгөөр бохирын шугам сүлжээний зураг төсөл, угсралт, цэвэрлэх байгууламж барьж, гүйцэтгэх ажлын санхүүжилтийг орон нутгийн төсвөөс гаргахаар гэрээнд тусгасан нь Засгийн газрын 2016 оны 37 дугаар тогтоолыг зөрчсөн, мөн уралдаант шалгаруулалтгүйгээр концессын гэрээг байгуулсан зэрэг нь ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй байна.

3. Концессын гэрээгээр хэрэгжүүлж байгаа 2 төсөл арга хэмжээг захиалагчийн техник хяналтгүйгээр гүйцэтгүүлж байгаа нь барилга, угсралтын ажлын чанарт сөрөг нөлөө бий болгож байна.
4. Эко хорооллын авто замын ажлын гүйцэтгэгч Монгол зам групп ХХК-д санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс 267.0 сая төгрөгөөр илүү олгосон байна.
5. Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн албан хаагч нар барилгын техник хяналт тавих чиг үүрэг байхгүй байтал төсөл арга хэмжээний гүйцэтгэл, төсөв санхүүгийн хяналт тавихтай холбоотой албан томилолт, тээвэр шатахуун, хоол, урамшууллын зардлыг барилгын техникийн хяналтын зардлаас гаргуулж, төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.
6. Зураг төсөвгүй болон зураг төсөв нь магадлалаар баталгаажаагүй 3 төсөл арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлсний улмаас барилгын техник хяналт хэрэгжээгүй байна.
7. Хөрөнгө оруулалтаар бий болсон барилга байгууламжийн төсөл арга хэмжээнүүд төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитаар өгсөн дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

АЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэст:

1. Тоног төхөөрөмжийн төсөл арга хэмжээний хувьд мэргэжлийн байгууллагаар зах зээлийн үнийн судалгаа хийлгэж, тухайн байгууллагын дүгнэлт, тайланд үндэслэсэн төсөвт өртгөөр орон нутгийн төсөвт төлөвлөж байх.
2. Магадлалын дүгнэлтгүй төсөл арга хэмжээг төсөвт тусгуулсан, тендер зарлахгүйгээр шууд гэрээ байгуулсан, барилгын ажил эхлэх зөвшөөрөлгүйгээр барилга угсралтын ажлыг эхлүүлсэн, бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосон, банкны баталгаагүйгээр урьдчилгаа санхүүжилт олгосон зэрэг зөрчилд холбогдох, буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцох.
3. Барилгын техник хяналт тавих чиг үүрэггүй албан хаагчдын албан томилолт, тээвэр шатахуун, хоол, урамшууллын зардлыг барилгын техникийн хяналтын зардлаас санхүүжүүлэхгүй байх, төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт:

1. Уулбаян, Түвшинширээ сумдад концессоор хэрэгжүүлж байгаа 2 төсөл арга хэмжээнд барилгын техник хяналт тавих гэрээг байгуулж, хяналт хэрэгжүүлэх.

2. Баруун-Урт сумын 3-р цэцэрлэгийн цэцэрлэгийн барилгын их засварын гүйцэтгэлийн төсөв нь бодит гүйцэтгэлээс зөрүүтэй байгаа тул өөрчлөлтийн төсвийг бодит гүйцэтгэлд үндэслэн гаргуулж, дахин хяналт тавьж баталгаажуулах.

Сүхбаатар хот байгуулалт, орон сууц, барилга захиалагч ОНӨААТҮГ-т:

1. Төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн төсвийг бодит гүйцэтгэлд үндэслэн баталгаажуулж ажиллах.

---oOo---